



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 4/319

Мандалговь

Аймгийн аварга малчин өрх
шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 222 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2021 оны А/21 дүгээр захирамжаар баталсан "Аймгийн аварга малчин өрх шалгаруулах журам", Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 40 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн үйлдвэрлэл, үр ашгийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг эзэмшин түүнийг боловсронгуй болгох, малын чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, мал сүргээ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулан эрүүлжүүлж бусдыгаа хошуучилж аймгийн аварга малчин өрхийн болзол хангасан малчдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, шагналын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шагналд шаардагдах 31,935,500 (Гучин нэгэн сая есөн зуун гучин таван мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111098